

НЯРАЙН ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ

Тасгийн үйл ажиллагаа, үндсэн чиглэл

ЭХЭМҮТ. Хүүхдийн эмнэлгийн Нярайн эрчимт эмчилгээний тасаг нь улсын хэмжээнд гуравдахь шатлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн лавлагаа эрүүл мэндийн тусламжийг бүрэн цогцоор нь үзүүлэх чадавхитай. Бид бусад мэргэжлийн байгууллага, анхан шат болон 1-2 дахь шатлалын амаржих газрууд, нярайн тусламж үзүүлж буй байгууллагуудад тасралтгүй нарийн мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ, ажлын байран дээр, орон нутагт очих, онлайн телемедицин ашиглан, алсын дуудлагаар хэрэгцээт газруудад ажиллах, нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж болон сургалт хосолсон чиглэлийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж байна. Монгол улсдаа Нярайн тусламжын чиглэлд дэлхийн түвшинд хүрсэн үйлчилгээг бий болгох, дэвшилтэт технологийг анхлан хэрэглэж эхлэн бусад шатлалын эмнэлгүүдэд түүчээлэн хэрэгжүүлэхэд манлайлан ажиллаж байна.

Хүний нөөц чадавхи, мэргэшсэн байдал

Нийт орон тоо 32 эмч эмнэлгийн ажилтантай. Тасгийн эрхлэгч эмч-1, их эмч 5, ээлжийн сувилагч 16, ахлах сувилагч, сувилгааны сувилагч, өдрийн сувилагч нийт -3, туслах сувилагч-3, үйлчлэгч 4 эмч эмнэлгийн ажилтаны бүрэлдэхүүнтэй ажиллах ёстой. Одоо ажиллаж байгаа 28 байна.

Мэргэжлийн багийн бүрэлдэхүүнд:

Эмч: тасгийн эрхлэгч Ч.Наранцэцэг Клиникийн профессор. АШУ магистр, тэргүүлэх зэрэгтэй, Ахлах зэрэгтэй эмч -1; Сувилахуйн ухааны магистр-1, сувилахуйн тэргүүлэх зэрэг-2, Ахлах зэрэг-8 тус тус сувилагч ажиллаж байна. Эмч эмнэлгийн мэргэжилтэнүүд өндөр хөгжилтэй орнууд Япон, БНСУ, Оросын холбооны улсуудад суралцаж мэргэшсэн байна.

Нярайн эрчимт эмчилгээний тасгийн орчин ба тоног төхөөрөмжүүд

Тус тасагт орчин үеийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр бүрэн хангагдсан нярайг дулаацуулах инкубатор, дулаацуулагч сэхээн амьдруулалтын хэрэгсэлүүд, фото эмчилгээний төхөөрөмж, өвчтөний амин үзүүлэлтийг хянах монитор, хүчилтөрөгч-агаарын холимог урсгалтай, дуслын болон тариураар хийх боломжтой автомат шахуургатай 24 цагийн турш эмчилгээг хийх боломжтой. Амьсгал орлуулах эмчилгээний аппаратууд: Drager Infinity-C500, Drager Evita-V600, Humming-VueMetran, iHope зэрэг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн өндөр чанартай үзүүлэлт бүхий нярайн зориулалтын аппаратуудыг хэрэглэж байна. Бид нярай хүүхдэд шаардлагатай бүх шинжилгээ оношлогоог эмчийн заавраар хийж үйлчилнэ. Өвчтөнийг тээвэрлэхгүйгээр оношлогоо шинжилгээг хийх боломж ЭХО аппарат, зөөврийн рентгэн бүхий аппарат төхөөрөмжүүдээр бүрэн тоноглогдсон. Мэргэсэн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нар тухайн заагдсан өдрүүдэд хуваарийн дагуу ирж үзлэг шинжилгээг хийнэ. Мөн хүнд өвчтэй эрчимт эмчилгээ хийгдэж байгаа нярайд судсаар эм, тарилгын шингэнийг хийх зорилгоор захын судсанд уян зүүгээр болон дутуу нярайд хоол сойгдох, хагалгааны дараах байдал зэрэг нь төвийн судсанд, захаар дамжуулан төвийн

гуурсыг тавьж эмчилгээг зориулалтын Дутуу болон гүйцэд нярайд зориулагдсан хоол тэжээлийн судсаар хийдэг бэлдмэлүүдийг Монгол улсдаа анх удаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тасгийн танилцуулга

	Тасгийн эрхлэгч Ч. Наранцэцэг Хүүхэд, нярайн эмч АШУ-ны магистр, докторант, Хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч ЭХЭМҮТ-ийн 2016 оны шилдэгч удирдагч Утас: 11362704 Цахим шуудан: chogdonnarantsetseg@gmail.com
	Зөвлөх эмч З.Гэрэлмаа МУ Хүний гавьяат эмч АУ доктор, профессор Зөвлөх зэргийн эмч
	Их эмч Н.Золжаргал Хүүхэд, нярайн эмч Утас: 11362704 Цахим шуудан: zojlazoloo@gmail.com
	Их эмч Майцэцэг Хүүхэд, нярайн эмч Утас:11362704 Цахим шуудан: MayaGunchin0501@gmail.com

	Их эмч Э.Мандахбилэг Хүүхэд, нярайн эмч Утас:11362704 Цахим шуудан: Mandakhaa164@gmail.com
	Их эмч Ө.Анар Хүүхдийн эмч Утас:11362704 Цахим шуудан: aanar9479@gmail.com
	Их эмч Г.Номин Хүүхдийн эмч Утас:11362704 Цахим шуудан: Nominganaa49@gmail.com



Ахлах сувилагч

Ж.Урангуа

Сувилахуйн ухааны магистр

Нярайн сувилагч

Тэргүүлэх зэрэгтэй

Цахим шуудан: ujanchiv@gmail.com



Сувилгааны сувилагч

Д. Ганцэцэг

Нярайн сувилагч,

Тэргүүлэх зэрэгтэй

Цахим шуудан: Ganaa3618@yahoo.com

Зураг 1: Тасгийн бүтэц зохион байгуулалт



Зураг 2. Зөвлөх эмч, тасгийн эрхлэгч эмч нарын хамтарсан үзлэг





Дутуу нярайн амьдрах чадвар

(TN<23wks BW<450 gr)

НЭҮНШТ

Blender oxygen therapy

Амьсгалын менежмент,

СУРФАКТАНТ

Коффейн цитрат

Хөхний сүүгээр хооллох, дэмжих

орчины таатай байдал, чийгшүүлэгтэй инкубатор сувилгаа



Удаан хугацааны амьсгалын эмчилгээ

(NeoPuff, IMV/PS, VG, CPAP, NIPPV, HFNC, BiPAP, HFO, nCPAP, RAM /Bubble CPAP)

Дутуу бага жинтэй нярайд үзүүлэх цогц тусламж

(дулаан алдалтаас сэргийлэх, байрлалын сувилгаа-үүр, толгойг эгц байрлуулах, хүзүү нугдайхаас сэргийлэх, ВЖК сэргийлэх, өдөр тутмын жингийн өсөлтийг хянах, амьсгалын аппараттай хүүхдэд үзүүлэх өвөрмөц сувилгаа)



Дутуу бага жинтэй нярайн эмчилгээ

Өсөлт хөгжлийн үнэлгээ

Өдөр тутмын биеийн жингийн нэмэгдүүлэх,

Нярайн инкубатор, дулаан зохицуулгыг хянах

Имж эх асаргаа

Мэдрэл дэмжих, дутуу нярайн цус харвалтаас сэргийлэх эмчилгээ

СДР нярайн амьсгалын үргэлжилсэн эмчилгээ

DART протокол , КС эмчилгээ

НЭК сэргийлэх, гэдэсний микробиом дэмжих

ДНР сэргийлэх ,

Блэндэрийн системээр хүчилтөрөгч өгөх

Судсаар бүрэн хооллох, илчлэг тооцоо

Стандарчлагдсан судсаар хооллолт эмчилгээ

Зураг 3 : Нярайн эрчимт эмчилгээний сувилагч нарын баг



Зураг 4: Тасгийн эмч сувилагчдын дотоод сургалтууд “Нярайн сэхээн амьдруулалт”-аар сургалт хийж байгаа байдал



